



НИЙГМИЙН УХААНЫ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН 11 АНГИ МАТЕРИАЛ
ВАРИАНТ А.

Нийгэм : Анги..... Нэр

СЭРГЭЭН САНАХ :

1. Нийгмийн давраажилтын хэв маяг үндэстний түүхийн онцлогоос хамааран өөр өөр байдаг. Ангийн давдраажилтын тогтолцоо хэзээнээс үүссэн бэ?
A. Эрт үед B. Дундад зууны үед C. Аж үйлдвэржилтийн үе D. Шинэ үе E. С ба D
2. Манай улсыг зорин ирсэн жуулчид аль аймгийг илүүтэй сонирхож аялдаг вэ?
A. Төв B. Өвөрхангай C. Өмнөговь D. Хөвсгөл E: Дээрх бугд
3. Валютын девальваци хэмээх ойлголтыг илэрхийлсэн тодорхойлолтыг доорх өгөгдлүүдээс сонгоно уу.
A. Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ
B. Төв бакнаас валютын ханшийг өсгөх үйл ажиллагаа
C. Төв бакнаас валютын ханшийг бууруулах үйл ажиллагаа
D. Төв банк өөрийн нөөцөөр валютыг худалдан авах үйл ажиллагаа
4. Засаглалын хүн амын нөөцөд холбогдох өгөгдөл аль нь вэ?
A. Материаллаг, соёл, мэдээллийн нөөцийг бүтээдэг хүмүүс
B. Хүчний байгууллага зэрэг тусгайлан бэлтгэсэн хүмүүс
C. Мөнгө санхүү, техник технологи, газар нутаг, ашигт малтмал
D. Засаглалыг дэмжинэ хэмээн найдаж байдаг бүлэг, давхраа
5.нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, шүүхийн шатанд байгаа болон хянан шийдвэрлэсэн эрүү, иргэний хэрэг, маргааны талаарх гомдолыг хүлээн авахгүй" гэж заасан байдаг. Цэгийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.
A.Хүний эрхийн үндэсний комиссын дарга B.Хүний эрхийн үндэсний комиссын нарийн бичгийн дарга C.Комиссын гишүүн D.Хүний эрхийн үндэсний комисс E.Тохирох хариулт алга
- 6."Олон нийтийн өмнө шүүхийн шийдвэрийг үншиж танилцуулах ,шүүхийн шийдвэрийн үндэслэлийг мэдэж авах, шүүхийн шийдвэрт гомдол гаргах хугацаатай байх" нь шударга шүүхээр шүүлгэх эрхийн аль агуулгад хамаарах вэ?
A.Хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрх B.Хуулийн дагуу байгуулагдсан бүрэн эрх бүхий шүүхээр шүүлгэх эрх C.Шударга шүүх хуралдаан хийлгэх эрх D.Гэм буруугүйд тооцогдох эрх E.Анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох эрх F.Шүүхийн шийдвэртэй холбогдох эрх
7. Бие даасан төр засагтай, тодорхой хил хязгаар бүхий газар нутагтай, нэгдмэл хэл ба соёл, иргэншлийн нийтлэгтэй, эдийн засгийн бие даасан тогтолцоотой, тусгаар тогтносон оронг олон улсын харилцаанд юу гэж нэрлэдэг вэ?
A. Тусгаар тогтносон улс B.Үндэстэн улс C. Бүрэн эрхт улс D. Улс маягийн байгууламж
8. Олон улсын эрх зүй болон ёс зүйн хариуцлагын үйлчлэх хүрээний ангиллыг дурьдахаа илүүц зүйл нэрлэсэн бол аль нь вэ?
A. Орон нутгийн B. Түгээмэл C. Бус нутгийн D. Нийтлэг

ОЙЛГОХ

- 9.Үйлдвэрт ямар машин техник авах вэ? гэдгийг шийдэхэд шууд оролцох боломжтой нь хэн байх вэ?
- A.Инженер техникийн ажилтан В.Менежер С.Жирийн ажилтан хүн D.А ба В Е. А,В,С
- 10.Монгол улсын «Соёлын үйлдвэрлэл» үндэсний хөтөлбөрийн зорилгыг олно уу.
- A. Соёлын үйлдвэрлэл эрхлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх
B. Соёлын салбарт хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх
C. Улс, үндэстнийхээ арвин баялаг өв уламжлал, ёс заншил, байгалийн өвөрмөц дүр төрх, соёлын нөлеөг сэргээх.
D. А ба В хариулт зөв Е. А, В, С хариулт зөв
- 11.Гадаадын шууд хөрөнгө оруулалт гэдэг ойлголтыг аль өгөгдөл нь зөв илэрхийлэх вэ?
- A. Улс орнуутдай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц үйл ажиллагаа
B. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрлэлээ байгуулах эсвэл худалдан авах үйл ажиллагаа
C. Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай томоохон компаниудын үйл ажиллагаа
D. Аль болох олон улс оронтой харилцан ашигтай байдлаар гадаад худалдаа, харилцаагаа өргөжүүлэн явуулах үйл ажиллагаа
- 12.Нээлттэй эдийн засгийн бодлого гэдэг ойлголтыг аль өгөгдөл нь зөв илэрхийлэх вэ?
- A. Улс орнуутдай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц үйл ажиллагаа
B. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрлэлээ байгуулах эсвэл худалдан авах үйл ажиллагаа
C. Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай томоохон компаниудын үйл ажиллагаа
D. Аль болох олон улс оронтой харилцан ашигтай байдлаар гадаад худалдаа, харилцаагаа өргөжүүлэн явуулах үйл ажиллагаа
- 13..... нь тухайн засаглалын оршин тогтох хугацааг харуулдаг үзүүлэлт юм.
Цэгийн оронд зөв өгөгдлийг нөхөж бичнэ үү.
- A. Засаглалын хэмжээ B. Засаглалын цаг хугацаа
C. Засаглалын орон зай D. Засаглалын эзлэхүүн
- 14.Эрх мэдэл хуулиар хязгаарлагдмал байх зарчмыг мөрдлөг болгодог засаглалын хэлбэрийг тэмдэглэнэ үү.
- A. Либераль засаглал B. Авторитари засаглал C. Тоталитари засаглал D. Үндсэн хуульт засаглал
- 15.Хүний эрхийн үндэсний комисс гомдлыг хуулийн дагуу хэд хоногийн дотор шийдвэрлэх вэ?
- A.14хоног B.21хоног C.30хоног D.45хоног E.60хоног
- 16.Захиргааны байгууллагын үйл ажиллагааны гол шинж юу вэ?
- A. Өдөр тутмын тасралтгүй байдагт B.Хуулийн хүрээнд
C.Нийгмийн бүлгийн эрх ашгийг хамгаалахад D.Нийгмийн доод давхаргад чиглэсэн
E.Дээрх бүгд
- 17.Олон улсын харилцаанд оролцогч субъект нь бусад улсын өмнө хүлээсэн үүргээ зөрчсөн тохиолдолд үүсэх хууль зүйн үр дагаврыг юу гэж нэрлэх вэ?
- A. Олон улсын эрх зүйн хариуцлага B. Олон улсын эрх зүйн хэм хэмжээ
C. Олон улсын эрх зүй D. Олон улсын эрх зүйн харилцаа

18. Монгол улс одоогийн байдлаар 160 гаруй улстай дипломат харилцаатай ажиллаж байгаа ба манай улсын хувьд ихээхэн ач холбогдолтой гэж үздэг олон улсын харилцааны бус нутагт аль нь үл хамаарах вэ?

A. Алс дорнод B. Зүүн ба зүүн өмнөд ази C. Зүүн хойд ази D. Төв ба еврази

ХЭРЭГЛЭХ :

19. Ямар байр суурь эзэлж байгаагаас хамааран шийдвэр гаргахад оролцох эрхтэй байгаа субъектын жишээг олно уу.

- A. Иргэн Б нь гутал засварын газарт оёдолчин хийж байгаа.
B. Иргэн М нь сургуулийн менежэрээр 5 жил ажиллаж байна.
C. Иргэн О нь одоогоор эрхэлсэн ажилгүй байна.
D. Иргэн Г нь талхны үйлдвэртэй болох төлөвлөгөөтэй байгаа
E. Дээрх бүгд

20. Нийгэм, эдийн засгийн байр суурыг хэмжих хэмжүүрийг зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|-------------------|---|---|
| a | Объектив хэмжүүр | 1 | Өөрийгөө ямар ангид эсвэл давхраанд хамаарулахыг хэлнэ. |
| b | Субъектив хэмжүүр | 2 | Боловсрол, орлого, ажил мэргэжил |

A. A1 b2

B. a2 b1

21. Соёлын үйлдвэрлэлийн ач холбогдоос илүүцийг сонгоно уу.

- A. Ажлын байр нэмэгдэх B. Улс орнуудыг соёл, ёс заншилаар нь ялган таниулах
C. ДНБ-ий хэмжээг нэмэгдүүлэх D. ҮНБ-ий хэмжээг бууруулах
E. Дэлхий нийтэд өөрсдийн брэндийг бий болгох

22. Даяаршлын эрсдэлтэй талыг сонгоно уу.

- A. Бусад соёлын үнэлээмж нэвтрэхээс зайлсхийх B. Соёлын ойртон нягтрах үйл явцыг шүүмжлэх C. Өөрийн соёлын зарим үнэт зүйл, амьдралын уламжлалт хэв маягаас татгалзах D. Үндэсний соёлын өвермөц шинжээ хадгалах E. Үндэсний онцлогийг алдахгүй байх

23. Эдгээрээс аль нь А. Смитийн үзэл санаанд хамаарах вэ?

- A. Зах зээлийн тогтолцоо нь эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч үл чадна.
B. Төрийн оролцоотойгоор нийт эрэлтийг нэмэгдүүлэх замаар эдийн засагт зохицуулалт хийх нь үр ашигтай.
C. Зах зээлийн харилцаа нь “үл үзэгдэгч гар”-ын онолын дагуу явагдвал илүү үр дүнд хүрнэ. D. Нийт эрэлтийг нэмэгдүүлэхдээ төрийн худалдан авалтын зардлыг аль болох чухалд үзэх хэрэгтэй.

24..... нь бүртгүүлсэн үнэт цаасыг андрейтарт худалдах, брокер, диллерийн компаниудад тараах үйл ажиллагаа юм. Цэгийн оронд нөхөж бичнэ үү.

- A. Үнэт цаас гаргах B. Үнэт цаас байршуулах
C. Үнэт цаас арилжих D. Үнэт цаасны зах зээл

25. Захирагдах сэдэл нь зүтгэх хүсэлд суурилдаг эрх мэдлийн хэлбэр аль нь вэ?

- A. Хүч хэрэглэх эрх мэдэл B. Наймаалцах эрх мэдэл
C. Үүрэг үүсгэх эрх мэдэл D. Зохицуулах эрх мэдэл

26. Улс төрийн тогтолцооны хүрээн дэх сонирхол илэрхийлэх үйл ажиллагааг ямар институт голлон гүйцэтгэдэг вэ?

- A. Сонирхолын бүлгүүд B. Улс төрийн намууд
C. Төрийн байгууллагууд D. Улс төрийн үүргүүд

27. Дүүргийн засаг даргыг шууд харьяалах дээд шатны захиргааны албан тушаалтан нь хэн бэ?

- A. Нийслэлийн засаг дарга B. Улсын их хурлын дарга C. Ерөнхий сайд
D. Ерөнхийлөгч E. Засгийн эрх авсан намын дарга

28. Захиргааны байгууллага, хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагаанд туслах чиг үүрэгтэй оролцож буй этгээдийг хэрхэн нэрлэдэг вэ?

- A. Хэргийн оролцогч B. Бусад оролцогч C. Шүүгч D. Шүүгчийн нарийн бичиг E. Дээрх бүгд

29. Захиргааны хэргийн оролцогчид анхан шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрвөл хэд хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд хандан гомдол гаргах эрхтэй вэ?

- A. 7 хоног B. 14 хоног C. 21 хоног D. 30 хоног E. 45 хоног

30. Дэлхийн улс орнууд өөр хоорондоо төр, засгийн газрынхаа түвшинд элчин төлөөлөгч солилцож, яриа хэлэлцээр явуулж, гэрээ байгуулан, тэдгээрт төрийн тэргүүнүүд нь гарын үсэг зурч, баталгаажуулах нь олон улсын харилцааны аль хэлбэр вэ?

- A. Улс төрийн харилцаа

- B. Эдийн засгийн харилцаа

- C. Соёлын харилцаа

- D. Хүмүүнлэгийн харилцаа

ХЭРЭГЛЭЭНИЙ ДААЛГАВАР :

1. Социологич Д.Датон ядуу хүмүүс бодит хэрэгцээнээсээ бага эрүүл мэндийн үйлчилгээ авч байгаа ямар саад бэрхшээлтэй холbon тайлбарладаг вэ? Зөв харгалзуулна уу. /4 оноо/

| | | | |
|---|--------------|---|---|
| 1 | Нэгдүгээрт | A | Ядуусын соёл |
| | Хоёрдугаарт | B | Нийгмийн институтийн саад бэрхшээлтэй холбоотой |
| 3 | Гуравдугаарт | C | Санхүүгийн боломж |

2. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд дутуу өгөгдлийг сонгоно уу./4 оноо /

| | | |
|---------------|-------------|-------|
| Байгаль орчин | Эдийн засаг | |
|---------------|-------------|-------|

3. Татвар хураалтын зарчмыг зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|--------------|---|--|
| a | Шудрага байх | 1 | Татвар төлөгчдийн татварын хэмжээ татвар хураах арга хугацааг урьдчилан мэдэгдсэн байх |
| б | Ил тод байх | 2 | Татвар нь хүмүүсийн орлоготой хамааралтай байх |

4. $b. M > \frac{PQ}{T}$ үед эдийн засагт ямар нөхцөл үүсэх вэ? Тайлбарлан бичнэ үү ? /4 оноо /

5. Сонирхлын бүлгийн хэв шинж, онцлогийг зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|---|---|--|
| A | Аномик | 1 | Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектийн шууд удирдлаган дор зохион байгуулалттай үүсгэн байгуулдаг |
| B | Эвсэл холбооны Associational | 2 | Зохион байгуулалтгүй боловч аномик бүлгээс ялгаатай нь хүмүүс голдуу яс үндэс, угсаа гарал, арьс өнгө, шашин шүтлэг, нас, хүйс зэрэг нийтлэгээрээ хамрагддаг |
| C | Эсвэл холбооны бус\Non Associational\ | 3 | Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт, бослого, үймээнийг хэлдэг |
| D | Байгуулагажсан institutional | 4 | Өөрийн гэсэн тодорхой зорилго, чиглэлд үндэслэгдсэн зохион байгуулалттай булаг |

6. Дэлхийн улс оронд сонирхлын бүлэг нь парламенттай хэрхэн харилцдаг болохыг зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|------------|---|--|
| A | Герман улс | 1 | Бундестагийн 7-р зүйлд дэд хороо болоод ажлын хэсэг нь сонирхлын бүлгээс мэргэжлийн хувьд заавар зөвлөгөө авч болохыг зөвшөөрсөн |
| B | АНУ | 2 | . Сонирхлын бүлгүүд нь мужийн засаг захиргаатай зөвшилцөлд хүрч чадахгүй байгаа нөхцөл уг асуудлаа нийт улсын хэмжээнд дэлгэн тавьж хуулиар шийдвэрлүүлэх. |
| C | Их Британи | 3 | Сонирхлын бүлгүүд нь гүйцэтгэх засаглалтай холбогддогийнхоо хувьд яамдын сайдууд болон иргэний төлөөлөгч нартай харилцдаг |

| | | | |
|---|--------------------------------|---|---|
| D | ОХУ ба Зүүн д Европын орнуудад | 4 | Сонирхлын бүлэг нь ихэвчлэн бизнесийн сонирхол дээр түшиглэдэг. |
|---|--------------------------------|---|---|

7.Хүний эрхийн үзэл баримтлалын гурван шинжийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|--------------|---|---|
| a | нэгдүгээрт | 1 | Аливаа эрх мэдэлд хязгаар бий |
| b | хоёрдугаарт | 2 | Хүн бүр эрхээ хамгаалулахаар төр,засагт гомдол,шаардлага гаргах эрхтэй. |
| c | гуравдугаарт | 3 | Хүн бүрд аливаа эрх мэдлийн зүгээс нөлөөлөх ёсгүй.өөрийн автономи эрх байдаг. |

8.“Зохиогчийн эрхийг зөрчих” гэмт хэргийн шийтгэлийг нь зөв холбоно уу.

| | |
|---------------------------------|---|
| A. Эрүүгийн хууль 2015 он | 1. -Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлс, хууль бусаар олсонхөрөнгө,оролгыг хурааж,үйл ажиллагааг нь зогсоож, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. - Хүнийг 500,000 төгрөгөөр, Хуулийн этгээдийг 5,000,000 төгрөгөөр торгоно. |
| B. Зөрчлийн тухай хууль 2017 он | 2. – 450,000 нэгжээс 5,400,000 төгрөгөөр торгох - 270-720 цаг хүртэл хугацаагаар нийтэд тусгай ажил хийлгэх - 1 сараас 1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах |

9. Олон улсын байгууллага, Олон улсын төрийн бус байгууллага хоёр нь зорилго, чиглэлийн хувьд харилцан адилгүй. Үүнийг зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|-----------------------------------|---|---|
| A | Олон улсын Байгууллага | 1 | Тодорхой, чиглэл, хүрээнд зорилго тавьж |
| B | Олон улсын төрийн бус байгууллага | 2 | Улс орны асуудалд тулхуу анхаардаг. |

10. Улс бус оролцогчдыг зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|--|---|---------------------------------|
| A | Олон улсын байгууллага. | 1 | Хил хязгааргүй эмч нар |
| B | Олон улсын төрийн бус байгууллага. | 2 | BBC, CNN |
| C | Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ | 3 | НҮБ |
| D | Үндэстэн дамнасан корпорацууд | 4 | Тоёото, Walmart |
| E | Нөлөө бүхий хувь хүн.. | 5 | Далай лам, Билл Гейтс |
| F | Шашны байгууллага. | 6 | Жихад, Аль Кайда бүлэглэл |
| G | Олон улсын гэмт хэргийн сүлжээ. | 7 | Буддын шашны төвүүд,Католик сүм |
| H | Террорист байгууллага, зэвсэгт бүлэглэгүүд | 8 | Хүн хулгайлах, зэвсгийн наймаа |

Хариулт бичнэ

| | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 1 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 2 | 3 |
| 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 0 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |



ЗАХИРАЛ
НИЙГМИЙН УХААНЫ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН МАТЕРИАЛ
ВАРИАНТ В

Нийгэм

Анги

Бүлэг

СЭРГЭЭН САНАХ :

1. Зарим хүн спорт, урлагийн авьяастай төрж, түүнийгээ хичээл зүтгэл, хөдөлмөрөөрөө тэтгэсний үр дүнд түмэн олноо гайхшуулсан амжилтанд хүрдэг. Энэ нь байр суурьт нөлөөлөх ямар хүчин зүйл вэ?

- A. Хувийн хүчин зүйл B. Институтийн хүчин зүйл C. Төрөлхийн авьяас чадвар
D. Байр суурьт хамаарахгүй E. Тохирох

2. Соёлын үйлдвэрлэл хэмээх ойлголт хэзээ бий болсон бэ?

- A. 1970-аад оны үе B. 1980-аад оны үе C. 1990-ээд оны эхэн
D. 1990-ээд оны төгсгөл E. 2000 оны эхэн

3. Нийт эрэлтийг нэмэгдүүлэх зорилгоор улсын орлого, зарлагыг өөрчлөх бодлого бол.....юм. Цэгийн оронд зөв өгөгдлийг нөхөж бичнэ үү.

- A. Сангийн буюу төсвийн бодлого B. Мөнгө, зээлийн бодлого
C. Олон улсын худалдаа D. Гадаад худалдааны бодлого

4. Засаглалын албадлагын нөөцөд холбогдох өгөгдөл аль нь вэ?

- A. Материаллаг, соёл, мэдээллийн нөөцийг бүтээдэг хүмүүс
B. Хүчний байгууллага зэрэг тусгайлан бэлтгэсэн хүмүүс
C. Мөнгө санхүү, техник технологи, газар нутаг, ашигт малтмал
D. Засаглалыг дэмжинэ хэмээн найдаж байдаг бүлэг, давхраа

5. "Алагчлалгүй, тэгш хүртээмжтэй байх" нь шударга шүүхээр шүүлгэх эрхийн аль агуулгад хамаарах вэ?

- A. Хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрх B. Хуулийн дагуу байгууллагдсан бүрэн эрх бүхий шүүхээр шүүлгэх эрх C. Шударга шүүх хуралдаан хийлгэх эрх D. Гэм буруугүйд тооцогдох эрх E. Анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох эрх
F. Шүүхийн шийдвэртэй холбогдох эрх

6. "Гэрч дуудаж оролцуулах, орчуулагч, хэлмэрч өмгөөлөгч авах эрх" нь шударга шүүхээр шүүлгэх эрхийн аль агуулгад хамаарах вэ?

- A. Хууль шүүхийн өмнө эрх тэгш байх эрх B. Хуулийн дагуу байгууллагдсан бүрэн эрх бүхий шүүхээр шүүлгэх эрх C. Шударга шүүх хуралдаан хийлгэх эрх D. Гэм буруугүйд тооцогдох эрх E. Анхан болон давж заалдах шатны шүүх хуралдаанд оролцох эрх
F. Шүүхийн шийдвэртэй холбогдох эрх

7. Монгол улсын гадаад бодлогод 1990 оноос хойш өргөн хэрэглэгдэх болсон гол нэр томьёо аль нь вэ?

- A. Гуравдагч хөрш B. Оюун санааны хөрш C. Хөрш орнууд D. Хоёр хөршийн харилцаа

8. 1618 – 1648 оны хооронд Европ тивд болсон 30 жилийн дайны төгсгөлд байгуулсан Вестфалийн энхийн гэрээгээр орчин үеийн олон улсын харилцааны түүх эхэлсэн байна. Энэхүү гэрээгээр орчин үеийн төрт улсыг хүлээн зөвшөөрдөг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн жишиг тогтсон нь Вестфалийн зарчим юм. Тэрхүү зарчмуудыг дурьдахаа илүүц зүйл нэрлэсэн бол аль нь вэ?

- A. Үндэсний төрт улсыг хүлээн зөвшөөрөх зарчим
B. Үндэсний ашиг сонирхлыг дээдлэх зарчим
C. Төрт улсын бүрэн эрхийн зарчим
D. Төрт улсын дотоод хэрэгт оролцох зарчим

ОЙЛГОХ :

- 9.Байр суурьт нөлөөлөх хувийн хүчин зүйлст хамаарах өгөгдлийг сонгоно уу.
A. Авьяас чадвар B. Хичээл зүтгэл C. Шаргуу хөдөлмөр D. Дээрх бүгд
- 10.Түүх, соёл, урлаг, амьдралын хэв маяг, үнэт зүйл, үнэлэмж, уламжлал зэрэг соёл хоорондын харилцааны олон хэлбэрийг багтаасан өөр соёлын орчинтой биечлэн танилцах аяллыг юу гэх вэ?
A. Соёлын үйлдвэрлэл B. Соёлын аялал жуулчлал C. Дотоодын аялал жуулчлал
D. Олон улсын аялал жуулчлал E. Соёлын орон зай
- 11.Валютын ревальваци хэмээх ойлголтыг илэрхийлсэн тодорхойлолтыг доорх өгөгдлүүдээс сонгоно уу.
A. Гадаадын нэгж валютыг өөрийн валютаар худалдан авах үнэ
B. Төв бакнаас валютын ханшийг өсгөх үйл ажиллагаа
C. Төв бакнаас валютын ханшийг бууруулах үйл ажиллагаа
D. Төв банк өөрийн нөөцөөр валютыг худалдан авах үйл ажиллагаа
- 12.Гадаад худалдааны бодлого гэдэг ойлголтыг аль өгөгдөл нь зөв илэрхийлж байна вэ?
A. Улс орнууттай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц үйл ажиллагаа
B. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрлэлээ байгуулах эсвэл худалдан авах үйл ажиллагаа
C. Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай томоохон компаниудын үйл ажиллагаа
D. Аль болох олон улс оронтой харилцан ашигтай байдлаар гадаад худалдаа, харилцаагаа өргөжүүлэн явуулах үйл ажиллагаа
- 13..... нь ямар нэгэн засгийн нөлөө, ач холбогдол, цар хүрээг тодорхойлох үзүүлэлт юм. Цэгийн оронд зөв өгөгдлийг нөхөж бичнэ үү.
A. Засаглалын хэмжээ B. Засаглалын цаг хугацаа
C. Засаглалын орон зай D. Засаглалын эзлэхүүн
- 14.Хязгаарлагдмал хяналттайгаар ганцаар захирах үйл ажиллагааг мөрдлөг болгодог засаглалын хэлбэрийг тэмдэглэнэ үү.
A. Либераль засаглал B. Авторитари засаглал
C. Тоталитари засаглал D. Үндсэн хуульт засаглал
- 15.Хүний эрхийн үндэсний комисс нэмэлт судалгаа, шалгалт хийх шаардлага хийх шаардлагатай бол хугацааг комиссын дарга хэд хүртэлх хоногоор сунгаж болдог вэ?
A.14хоног B.21хоног C.30хоног D.45хоног E.60хоног
- 16.Дэлхийн II дайны дараа 1990 он хүртэл олон улсын харилцаанд бүрэлдэн 30.Хэдэн онд “Төлбөрийн чадваргүй яллагчдад үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хууль баталсан бэ?
A.2000 B.2003 C.2013 D.2015 E.2019
- 17.Зөв харгалзуулна уу

| Байгууллага | Үйл ажиллагаа | |
|-----------------|---------------|--|
| a УИХ | 1 | Хүний эрх зөрчсөн тухай нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх |
| b Засгийн газар | 2 | Хууль тогтоох замаар хүний эрхийг хангах бодлого, эрх зүйн орчныг бүрдүүлэх, Засгийн газрын үйл ажиллагаанд хяналт тавих |
| c Шүүх | 3 | Хүний эрхийн талаарх хууль тогтоомж, олон улсын гэрээний биелэлтийг хангах, үр дүнг УИХ, НҮБ-д тогтмол тайлагнах |

A. A1b2c3 B. a2b3c1 C. a3b1c2

18. 1975 оны 11 сард Францын ерөнхийлөгч Жискар де Эстен, ХБНГУ –ын канцлер Гельмут Шмидт нар тохиролцож Францын Рамбуйед их долоогийн уулзалтыг анх эхэлсэн ба 1997 оноос Их наймын уулзалт гэж нэрлэх болсон байна. Тэгвэл Их наймын уулзалтанд оролцдоггүй улс аль нь вэ?

A. Канад B. Япон C. Испани D. Итали

19. Орчин үеийн нийгэмд бюрократ байгууллагад эрх мэдэл ажилтнуудад тэгш бусаар хуваарилагдсан байдаг нь ямар ангид хуваагдахад хүргэдэг вэ?

A. Дээд анги ба Доод анги B. Дунд анги ба Доод анги

C. Ноёрхогч ба Доод анги D. Ноёрхогч хийгээд Дагагч E. Дээрх бүгд буруу

20. Америкийн судлаач Θ. Күүсийн судалгааны

| | | | |
|---|--|---|--|
| 1 | Нэг дэхангийн хүмүүс өвчний шинж тэмдэг нь илрэхэд | a | 75 хувь нь өвчний 17 шинж тэмдгийн 10 шинж тэмдгийг эмнэлэгт үзүүлэх ноцтой биш шинж гэж үзэж байна. |
| 2 | Гурав дахангийн хүмүүс - | b | Эмчид хандаж эрүүл мэндийн үйлчилгээ авахаар эрэлхийлэхэд бэлэн байв |

A. 1a 2b B. 1b 2a

21. Соёлын үйлдвэрлэлд оюуны өмч, зохиогчийн эрхтой холбоотой бүтээл, туурвил, үйлчилгээ багтдаг. Илүүц зүйлийг олно уу.

A. Археологи B. Архитектур C. Гар урлал D. Үндэсний тоглоом E. Богд хан уул

22. Тогтвортой хөгжлийн узэл баримтлалын үндэс юунд оршиж байна ва?

A. Байгаль, нийгмийн хөгжлийн зүй тогтлыг алдагдуулахгүй байх B. Ёс суртахууныг дээдлэх C. Нийгмийн хариуцлагаа биелүүлэх D. Сахилгыг өндөржүүлэх

E. Дээрх бүгд

23. Үндэстэн дамнасан корпарци гэдэг ойлголтыг аль өгөгдөл нь зөв илэрхийлж байна вэ?

A. Улс орнуудтай тогтоосон худалдааны харилцааг зохицуулах зорилгоор төрөөс хэрэгжүүлж байгаа арга хэмжээний нийлбэр цогц үйл ажиллагаа

B. Бүтээгдэхүүн экспортлохын оронд гадаадад үйлдвэрлэлээ байгуулах эсвэл худалдан авах үйл ажиллагаа

C. Гадаад орнуудад хоёр болон түүнээс олон үйлдвэрлэл, үйлчилгээний салбартай томоохон компаниудын үйл ажиллагаа

D. Аль болох олон улс оронтой харилцан ашигтай байдлаар гадаад худалдаа, харилцаагаа өргөжүүлэн явуулах үйл ажиллагаа

24. Эдгээрээс аль нь Ж.Кейнсийн үзэл санаанд хамаarahгүй вэ?

A. Зах зээлийн тогтолцоо нь эдийн засгийн уналтаас өөрийгөө аварч үл чадна

B. Төрийн оролцоотойгоор нийт эрэлтийг нэмэгдүүлэх замаар эдийн засагт зохицуулалт хийх нь үр ашигтай.

C. Зах зээлийн харилцаа нь “үл үзэгдэгч гар”-ын онолын дагуу явагдвал илүү үр дүнд хүрнэ. D. Нийт эрэлтийг нэмэгдүүлэхдээ төрийн худалдан авалтын зардлыг аль болох чухалд үзэх хэрэгтэй.

D. Гүйлгээнд байгаа мөнгөний тоо хэмжээнд өөрчлөлт гарагчгүй.

25. Харилцааны төрөл нь ашигтай солилцоонд тулгуурладаг эрх мэдлийг юу гэж нэрлэдэг вэ?

A. Хүч хэрэглэх эрх мэдэл B. Наймаалцах эрх мэдэл

C. Үүрэг үүсгэх эрх мэдэл D. Зохицуулах эрх мэдэл

26. Сонирхлын бүлгийг үйл ажиллагааны хүрээ, чиглэлээр дараах хэсгүүдэд хуваадаг.

Үүнийг зөв харгалзуулна уу?

| | | | |
|---|--|---|---|
| A | Амралт чөлөөт цагийн бүлэгт | 1 | Сүм хийд шашний байгууллага |
| B | Эдийн засаг, аж ахуй, үйлдвэрлэгчдийн бүлэнт | 2 | Нийгмийн халамж, эмэгтэйчүүдийн байгууллага |

| | | | |
|--|---|---|---|
| C | Шинжлэх ухаан, соёл урлаг, боловсролын бүлэгт | 3 | Боловсрол олгох, мэргэжил дээшлүүлэх байгууллага |
| D | Нийгмийн асуудал болон эрүүл мэндийн бүлэгт | 4 | Цэцэг жимс, мод таригчдын, марк цуглуулагчдын төгөлдөр хуурчдын, хөл бөмбөг сонирхогчдын фен клуб |
| E | Үзэл суртал, Шашны чиглэлийн бүлэгт | 5 | Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүд |
| A.a5 b1 c4 d2 e3 B.a4 b2 c3 d5 e1 C.a3 b1 c2 d4 e5 D.a2 b4 c1 d5 e3 E.a4 b5 c3 d2 e1 | | | |

27. Захиргааний хэрэг урьдчилан шийдвэрлэх ажиллагааны чиглэл нь ямар байдаг вэ?

A. Нийтийн захиргааны байгууллагад өөрийн хяналтыг хэрэгжүүлэх боломж олгох
ВИргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг захиргаан хэргийг урьчилан шийдвэрлэх ажиллагааны явцап хатгаалах

С. Захиргааний акт хууль тогтоомжид нийцсэн эсэхийг шалгах

Д. Гомдол гаргагчид тухайн актыг шийдвэрлэх хугацаа, газрыг мэдэгдэж түүнийг одолцуулах

Е. А ба В

28. Императив болон диспозитив хэм хэмжээг олон улсын гэрээний эрх зүйн тухай

Венийн конвенцид ямар журмаар тодорхойлж өгсөн байдаг вэ?

А. Дүрэм В. Тунхаглал С. Нэмэлт өөрчлөлт D. Гэрээ

29. Олон улсын Төрийн бус байгууллагууд үндэстэн дамнасан.....

асуудлуудад байнга анхаарч ажилладаг. Цагийн оронд тохирох өгөгдлийг сонгоно уу.

А. Нийгэм, хүмүүнлэг B. Нийгэм, эдийн засаг C. Нийгэм, улс төр D. Олон улсын харилцаа
E. Соёл, шинжлах ухаан

30. Ватикан, Исламын шашны байгууллага нь улс бус оролцогчдын аль ангилалд хамаарах вэ?

A. Олон улсын байгууллага B. Террорист байгууллага, зовсэгт бүлэглэлүүд C. Олон улсын гэмт хэргийн сүлжээ

D. Үндэстан дамнасан корпораци E. Шашны байгууллага

Хэрэглээний даалгавар

1. Судлаач Ц. Уртнасангийн судалгааны үр дүнг харгалзуулна уу.

| | | | |
|---|------------------|---|----------------------------|
| a | Дээд анги | 1 | Нийт хүн амын - хувь |
| b | Дундын дээд анги | 2 | Нийт хүн амын – орчим хувь |
| c | Дундын доод анги | 3 | Нийт хүн амын - хувь |
| | | | |

2.. Соёлын харилцан үйлчлэлийн хэлбэруудээс цэгийн оронд тохирох өгөгдлийг нөхөж бичнэ уу .

| | | |
|-----------------|-------|----------------|
| Соёлын солилцоо | | Соёлын тулгалт |
|-----------------|-------|----------------|

3. Татвар хураалтын зарчмыг зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|--------------|---|--|
| a | Ил тод байх | 1 | Татвар төлөгчдийн татварын хэмжээ татвар хураах арга хугацааг урьдчилан мэдэгдсэн байх |
| б | Шудрага байх | 2 | Татвар нь хүмүүсийн орлоготой хамааралтай байх |
| | | | |

4. a. $M = \frac{PQ}{T}$ үед эдийн засагт ямар нөхцөл үүсэх вэ? Тайлбарлан бичнэ уу ?

5. Сонирхлын бүлгийн хэв шинж, онцлогийг зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|------------------------------------|---|--|
| A | Байгуулагажсан institutional | 1 | Тодорхой зохион байгуулалтгүй хэсэг бөөн хүмүүсийн цугларалт, бослого, үймээнийг хэлдэг |
| B | Эсвэл холбооны бус Non Association | 2 | Зохион байгуулалтгүй боловч аномик бүлгээс ялгаатай нь хүмүүс голдуу яс үндэс, угсаа гарал, арьс өнгө, шашин шүтлэг, нас, хүйс зэрэг нийтлэгээрээ хамрагддаг |

| | | | |
|---|---------------------------------|---|--|
| C | Эвсэл холбооны Associational | 3 | Цэрэг зэвсэглэл, арми, сүм хийд зэрэг субъектийн шууд удирдлаган дор зохион байгуулалттай үүсгэн байгуулдаг |
| D | Аномик | 4 | Өөрийн гэсэн тодорхой зорилго, чиглэлд үндэслэгдсэн зохион байгуулалттай бүлэг |

6. Дэлхийн улс оронд сонирхлын бүлэг нь парламенттai хэрхэн харилцаг болохыг зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|--------------------------------------|---|---|
| A | АНУ | 1 | Бундестагийн 7-р зүйлд дэд хороо болоод ажлын хэсэг нь сонирхлын бүлгээс мэргэжлийн хувьд заавар зөвлөгөө авч болохыг зөвшөөрсөн |
| B | Герман улс | 2 | . Сонирхлын бүлгүүд нь мужийн засаг захиргаатай зөвшилцэлд хүрч чадахгүй байгаа нөхцөлд уг асуудлаа нийт улсын хэмжээнд дэлгэн тавьж хуулиар шийдвэрлүүлэх. |
| C | ОХУ ба Зүүн д Европын орнуудад | 3 | Сонирхлын бүлгүүд нь гүйцэтгэх засаглалтай холбогддогийнхоо хувьд яамдын сайдууд болон иргэний төлөөлөгч нартай харилцаг |
| D | Их Британи | 4 | Сонирхлын бүлэг нь ихэвчлэн бизнесийн сонирхол дээр түшиглэдэг. |

7. Зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|--------------|---|--|
| a | Тунхаглал | 1 | Хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээнд нэмэлт ,өөрчлөлт оруулсан бичиг баримт |
| b | Конвенц,пакт | 2 | Хуульчлан дагаж мөрдөх албагүй зөвлөмж уриалгын шинжтэй баримт бичиг |
| c | Протокол | 3 | 2 болон түүнээс дээш улс хуульчлан дагаж мөрдөхөөр баталсан хүний эрхийн гэрээ |

8. "Хүүхэдтэй хэрцгий харилцах" гэмт хэрэгт тохирох хуулийн агуулагтай нь зөв холбоно уу

| | |
|------------------------------------|---|
| A. Эрүүгийн хууль 2015 он | 1. Хүүхдийн эрхийг зөрчсөн ноцтой үйлдэл гаргасан багш, сурган хүмүүжүүлэгч, асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн үйлдсэн. |
| Зөрчлийн тухай хууль 2017 он | 2. Сургууль, сургуулийн дотуур байр, тэдгээрийн гаднах орчинд сурагч бусад сурагчийг дарамталж, зүй бусаар харьцаж сургуульд суралцах боломжгүй байдлыг бий болгосон. |

9. Олон улсын байгууллага, Олон улсын төрийн бус байгууллага хоёр нь бүтэц, зохион байгуулалтын хувьд харилцан адилгүй. Үүнийг зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|---|---|--|
| A | Олон улсын байгууллага | 1 | улс орнуудад илүү нээлттэй, байгууллагын бүтэцтэй, гишүүн улс орнуудын эрх ашгийг хамгаалах, хамтран ажиллах чиглэлд илүү анхаардаг. |
| B | Олон улсын терийн бус байгууллага | 2 | Иргэн, байгууллагад түлхүү нээлттэй, сайн дурын шинжтэй, иргэний нийгмийн олон чиглэлээр үйлажиллагаа явуулдаг. |

10. Улс бус оролцогчдыг зөв харгалзуулна уу.

| | | | |
|---|---|---|----------------------------------|
| A | Шашны байгууллага. | 1 | Хил хязгааргүй эмч нар |
| B | Үндэстэн дамнасан корпорацууд | 2 | BBC, CNN |
| C | Олон улсын байгууллага | 3 | НУБ |
| D | Олон улсын төрийн бус байгууллага. | 4 | Тоёото, Walmart |
| E | Нэлээ бүхий хувь хүн.. | 5 | Далай лам, Билл Гейтс |
| F | Олон улсын хэвлэл мэдээллийн сүлжээ | 6 | Жихад, Аль Кайда бүлэглэл |
| G | Олон улсын гэмт хэргийн сүлжээ. | 7 | Буддын шашны төвүүд, Католик сүм |
| H | Террорист байгууллага, зэвсэгт бүлэглэгүүд | 8 | Хун хулгайлах, зэвсгийн наймаа |